

ХИЛИЙН АЛБАНЫ МЭРГЭЖИЛ ЭЗЭМШҮҮЛЭХ ЭРХЗҮЙН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

THE ANALYSIS OF THE IMPLEMENTATION OF LEGAL DOCUMENTS REGULATING BORDER SERVICE PROFESSIONAL TRAINING



Хилийн албаны мэргэжил эзэмшүүлэх эрхзүйн баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн шинжилгээ

Б.Түмэнжаргал

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн Хилийн стратеги-8022 дугаар дамжааны суралцагч, докторант

B.Tumenjargal

Doctoral Student, Border Strategy Class No 8022, Academy of Management, University of Internal Affairs

*хариуцлагатай зохиогч: bayanzultumenjargal181@gmail.com

Хураангуй: Улсын хил хамгаалах үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг бөгөөд тус үйл ажиллагааны үр нөлөөтэй байдлыг хангахын тулд мэргэжлийн өндөр ёс зүйтэй, эх оронч хүмүүжилтэй боловсон хүчнийг бэлтгэх асуудал онцгой ач холбогдолтой юм. Хилийн албаны мэргэжил эзэмшүүлэх үйл ажиллагаа нь зөвхөн боловсролын салбарт хамаарах асуудал биш бөгөөд батлан хамгаалах, хууль сахиулах, аюулгүй байдлын бодлого, эрх зүйн зохицуулалттай нягт уялдаа холбоотой цогц үйл ажиллагаа юм.

Энэхүү үйл ажиллагаа нь улсын хил хамгаалах байгууллагын бүтцийн онцлог, үүрэг чиглэл, хүний нөөцийн бодлоготой уялдах бөгөөд түүнийг эрх зүйн хувьд оновчтой зохицуулах нь хил хамгаалах үйл ажиллагааны үр ашиг, бие даасан чадамжид шууд нөлөөлнө. Хууль, эрх зүйн зохицуулалт нь хилийн албаны мэргэжил эзэмшүүлэх хөтөлбөрийн зорилго, агуулга, сургалтын үр дүнг тодорхойлох суурь баримт бичиг болдог тул эдгээр баримт бичгийн хэрэгжилтийн түвшин нь боловсон хүчний чанарыг тодорхойлох гол үзүүлэлт гэж үзэж болно.

Иймд энэхүү судалгааны зорилго нь хилийн албаны мэргэжилтэн бэлтгэхтэй холбоотой хууль, эрх зүйн баримт бичгүүдийн хэрэгжилтийн бодит байдалд судалгаа, шинжилгээ хийх, тэдгээрийн уялдаа, үр нөлөөг үнэлэх, хэрэгжилтийн явцад үүсэж буй зөрчил, хүндрэл, сул талуудыг тодорхойлох, улмаар бодлогын түвшинд шаардлагатай сайжруулалтын чиглэл, арга замыг санал болгоход оршино.

Судалгааны ажлын үр дүнгээр хилийн албаны мэргэжил эзэмшүүлэх үйл ажиллагааны эрх зүйн орчны бодит хэрэгжилт, түүний оновчтой байдлыг үнэлэх замаар боловсролын чанар, мэргэжлийн чадамжийг дээшлүүлэхэд шаардлагатай эрх зүйн шинэчлэлийн чиг хандлагыг тодорхойлох боломж бүрдэнэ.

Abstract: The protection of a state border is an integral component of national security. Ensuring the effectiveness of this activity requires the preparation of highly professional personnel with strong ethical standards and patriotic values. The process of training specialists for the Border Service is not solely an educational matter but a comprehensive activity closely linked with national defense, law enforcement, and security policies, as well as with legal regulations.

This process must align with the structural characteristics, duties, and human resource policies of the border protection organization. Proper legal regulation has a direct impact on the efficiency and autonomy of border protection activities. Legal and regulatory documents serve as the foundation for defining the objectives, content, and outcomes of border service training

programs; therefore, the level of their implementation is a key indicator of the quality of personnel training.

The purpose of this research is to analyze the actual implementation of laws and legal documents related to border service professional training, assess their coherence and effectiveness, identify conflicts, difficulties, and weaknesses arising during implementation, and propose policy-level improvements and solutions.

As a result of the study, it becomes possible to evaluate the current implementation of the legal framework governing border service professional training and determine directions for necessary legal reforms aimed at enhancing the quality of education and professional competence.

Түлхүүр үг: Хилийн албаны мэргэжил, эрх зүйн зохицуулалт.

Keywords: Border Service Profession, Legal Regulation

(Хилийн албаны мэргэжил эзэмшүүлэх хууль, эрх зүйн зохицуулалт нь хилийн аюулгүй байдлыг хангах, хүний нөөцийн бодлогыг оновчтой хэрэгжүүлэх, мэргэжлийн чадамж болон боловсролын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн цогц ойлголт юм).

Үндсэн хэсэг

Хилийн албаны мэргэжил эзэмшүүлэх үйл ажиллагааны эрх зүйн орчин

Хилийн албаны мэргэжил эзэмшүүлэх үйл ажиллагаа нь Монгол Улсын хууль тогтоомж болон холбогдох эрх зүйн баримт бичгүүдэд тулгуурлан хэрэгждэг. Эдгээр баримт бичгүүд нь зөвхөн сургалтын зорилго, бүтэц, агуулгыг тодорхойлоод зогсохгүй үндэсний аюулгүй байдал, баглан хамгаалах бодлогын хүрээнд хүний нөөцийн оновчтой төлөвлөлт, мэргэжлийн чадамжийг бий болгох суурь нөхцөлийг бүрдүүлдэг. Иймд хилийн албаны мэргэжил эзэмшүүлэх үйл ажиллагаа нь төрийн бодлого, хууль эрх зүйн зохицуулалт, боловсролын тогтолцооны нэгдмэл уялдаа холбоонд тулгуурлан хэрэгжих онцлогтой.

Хилийн албаны мэргэжил эзэмшүүлэх үйл ажиллагаа нь дараах эрх зүйн баримт бичгүүдэд үндэслэж байна Үүнд:

Үндсэн хууль нь төрийн байгууламж, хүний эрх, үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоог тодорхойлох суурь баримт бичиг бөгөөд улсын хил, түүний халдашгүй дархан байдлыг хангах тухай заалтуудаараа хил хамгаалах үйл ажиллагаанд эрх зүйн дээд үндэслэл болдог. (Монгол Улсын Үндсэн хууль, 1992)

Хилийн тухай хууль нь хил хамгаалах үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, хил хамгаалах

байгууллагын чиг үүрэг, бүтэц, үйл ажиллагааны зохицуулалтыг нарийвчлан тогтоосон байдаг. Түүнчлэн, хил хамгаалах байгууллагын боловсон хүчний бэлтгэл, мэргэжлийн шаардлагад шууд хамааралтай эрх зүйн эх сурвалж юм. (Хилийн тухай хууль, 2016)

Боловсролын ерөнхий хууль нь улсын хэмжээнд боловсролын ерөнхий тогтолцоог тодорхойлох бөгөөд хилийн албаны мэргэжил эзэмшүүлэх үйл ажиллагааг боловсролын бодлоготой уялдуулах эрх зүйн үндсийг бүрдүүлдэг. (Боловсролын ерөнхий хууль, 2023)

Дээд боловсролын тухай хууль нь дээд боловсролын байгууллагын үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрийн стандарт, багш, судлаачдын шаардлага, оюутны эрх зэргийг зохицуулж, мэргэжлийн сургалтын чанар, үр дүнг баталгаажуулах эрх зүйн суурь болдог. (Дээд боловсролын тухай хууль, 2023)

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль нь техникийн болон мэргэжлийн чиглэлээр боловсон хүчнийг бэлтгэх, сургалтын агуулга, хөтөлбөр, багшлах болон үнэлгээний стандарт, мэргэжлийн ур чадварын шаардлагыг тодорхойлдог бөгөөд хилийн албаны мэргэжилтний техникийн болон тусгай ур чадварыг эзэмшүүлэх эрх зүйн суурь болдог. (Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын тухай хууль, 2023)





ХҮҮЛЬ САХИУЛАХУЙ

Цэргийн албаны тухай хууль нь цэргийн албыг гүйцэтгэх журмыг тогтоож, цэргийн албан хаагчдын бэлтгэл, сахилга бат, үүрэг хариуцлага, албаны дэг журамтай холбоотой зохицуулалтыг агуулдаг. Хилийн албаны мэргэжил эзэмшүүлэх үйл ажиллагаа нь цэргийн албаны үндсэн зарчим, дэг журамтай нягт уялдаатай тул сургалтын агуулга, хүмүүжлийн чиглэлд энэ хуулийн хэрэгжилт чухал ач холбогдолтой. (Цэргийн албаны тухай хууль, Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, 2016)

Төрийн албаны тухай хууль нь төрийн албанд ажиллаж буй албан хаагчдын эрх, үүрэг, мэргэжлийн шалгуур, ёс зүй, хариуцлагыг тодорхойлдог. Хил албаны мэргэжил нь төрийн тусгай албанд хамаарах тул хүний нөөцийг бэлтгэх, албан тушаалын томилгоо, мэргэжлийн үнэлэмж, тогтвортой байдлыг зохицуулдаг. (Төрийн албаны тухай хууль, 2017)

Цэргийн албан хаагчдын эрх зүйн байдлын тухай хууль нь цэргийн албан хаагчдын нийгмийн баталгаа, ажиллах нөхцөл, цалин, тэтгэвэр, халамж, эрх ашгийн хамгаалалтыг тодорхойлдог. Хилийн албаны мэргэжил эзэмшүүлэх үйл ажиллагааны чанар, төгсөгчдийн мэргэжлийн тогтвортой байдал нь зөвхөн боловсролын тогтолцооноос хамаарахгүй, харин энэхүү хуулиар баталгаажсан нийгмийн баталгаа, эрх зүйн хамгаалалттай салшгүй холбоотой юм. (Цэргийн албан хаагчдын эрх зүйн байдлын тухай хууль, 2016)

Их сургуулийн дүрэм нь тус сургуулийн бүтэц, сургалтын зохион байгуулалт, хөтөлбөрийн хэрэгжилтийн үндсэн чиглэлийг энэхүү дүрэм тодорхойлдог. Энэ нь мэргэжлийн сургалтын чанарт шууд нөлөөлөх дотоод зохицуулалтын баримт бичиг юм. (Дотоод хэргийн их сургуулийн дүрэм, 2024)

Хил хамгаалах байгууллагын дотоод журам нь байгууллагын сахилга, дэг журам, алба хаагчдын ёс зүйн хэм хэмжээ, хариуцлага, сургалт, дадлагын онцлогийг зохицуулдаг. Энэ нь мэргэжлийн хүмүүжил, эх оронч үзлийг төлөвшүүлэхэд

ач холбогдолтой. (Хил хамгаалах байгууллагын дотоод журам, 2021)

Сургалтын хөтөлбөр нь хөтөлбөрийн зорилго, зорилт, суралцагчийн эзэмших мэдлэг, чадвар, хандлага төлөвшил, сургалтын арга зүй, үнэлгээ сайжруулалтын төлөвлөлт болон сургалтын орчин, хэрэглэгдэхүүн, багшлах бүрэлдэхүүн, элсэгч, төгсөгчид тавигдах шаардлагыг тусгасан цогц баримт бичиг юм. (Дээд боловсролын сургалтын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага, 2024)

Сургалтын хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх явцад дээр дурдсан хууль, дүрэм, журам зэрэг эрх зүйн баримт бичгүүдийг мөрдлөг болгон ашигладаг. Эдгээр эрхзүйн баримт бичгүүд нь хилийн албаны мэргэжил эзэмшүүлэх үйл ажиллагааг хууль эрх зүйн хүрээнд албан ёсоор баталгаажуулж байна.

Хэрэгжилтийн байдалд хийсэн шинжилгээ

Эрхзүйн орчны хэрэгжилт: Хилийн албаны мэргэжил эзэмшүүлэх үйл ажиллагаа нь Монгол Улсын боловсролын болон батлан хамгаалах, хууль сахиулах салбарын холбогдох хууль, эрх зүйн баримт бичгийн хүрээнд хэрэгжиж байгаа хэдий ч зарим зохицуулалтын бүрэн бус байдал ажиглагдаж байна. Тухайлбал, “хилийн албаны мэргэжил” гэсэн нэр томьёо нь боловсролын болон төрийн тусгай албаны, мэргэжлийн ангиллын жагсаалтад албан ёсоор тусгагдаагүйгээс сургалтын хөтөлбөрийн эрх зүйн үндэс тодорхой бус, улмаар мэргэжлийн үнэлгээ, боловсролын зэрэг олголтод тодорхой бус байдал үүсгэж байна. Энэ нь зөвхөн сургалтын чанар, баталгаажуулалтад нөлөөлөөд зогсохгүй, хөдөлмөрийн зах зээл дэх мэргэжлийн үнэлэмж, хүлээн зөвшөөрөлтөд сөрөг нөлөө үзүүлж байна.

Хөтөлбөрийн хэрэгжилт: Их сургуулийн Хилийн албаны сургуулийн сургалтын хөтөлбөр нь “Хилийн аюулгүй байдлыг хангах”-д чиглэгдэж байгаа боловч ч хөтөлбөрийн бүтэц, үнэлгээний аргачлал нь боловсролын ерөнхий стандарт, чанарын баталгаажуулалтын шалгуур үзүүлэлттэй бүрэн уялдаагүй байна. Ялангуяа сургалтын агуулга нь онол,

практикийн хослолыг бүрэн дүүрэн хангахгүй байгаа нь олон улсын боловсролын хөтөлбөрийн чиг хандлагаас хоцрогдох эрсдэлтэй байна. Энэ нь боловсролын нийтлэг тогтолцоо нь цэргийн боловсролын онцлог шаардлагад бүрэн нийцэхгүй байгаатай холбоотой юм. Нийтлэг боловсролын тогтолцоонд тулгуурласан хөтөлбөр нь тусгай мэргэжлийн сургалтын зорилт болох дадлага, ур чадварын хөгжүүлэлт, чадавх, команд-штабын түвшний сургалтын онцлогтой уялдахгүй байгаа нь цэргийн боловсролын чанар, үр дүнд сөргөөр нөлөөлөх нөхцөл болж байна.

Институцийн уялдаа холбоо: Хилийн албаны мэргэжил эзэмшүүлэх үйл ажиллагаа нь зөвхөн их, дээд сургуулийн боловсролын агуулгаар хязгаарлагдахгүй бөгөөд захиалагч байгууллага болох Хил хамгаалах байгууллагын хүний нөөцийн бодлого, мэргэжлийн шаардлагатай салшгүй уялдаатай юм. Иймд боловсон хүчний мэргэжлийн ур чадвар, ажил үүргийн онцлогт нийцсэн сургалтын хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх үйл явцад захиалагч байгууллагын идэвх оролцоо зайлшгүй шаардлагатай. Одоогийн байдлаар “сургалтын хөтөлбөр”-үүдийг Их сургууль дангаар боловсруулж, баталгаажуулдаг бөгөөд захиалагч байгууллагын оролцоо хангалтгүй байна. Үүний улмаас төгсөгчдийн мэргэжлийн ур чадвар нь бодит шаардлагад бүрэн нийцэхгүй, байгууллагын зүгээс зөвхөн шүүмжлэл хэлэх түвшинд хязгаарлагдан, хариуцлагын механизм бүрэлдэж чадахгүй байгаа нь томоохон сул тал болж байна.

Иймд хөтөлбөр боловсруулах үйл явцыг хамтын оролцоо, хариуцлагын хуваарилалт дээр суурилуулах шаардлагатай. Тодруулбал:

- ✓ Хил хамгаалах байгууллагаас боловсон хүчний мэргэжлийн шаардлагыг нарийвчлан оновчтой тодорхойлох;
- ✓ Их сургуулийн багш, судалгааны багтай хамтран хөтөлбөрийн агуулга, стандарт, сургалтын арга зүйг хамтран боловсруулах;

- ✓ Хөтөлбөрийг баталгаажуулахдаа байгууллагын болон их сургуулийн удирдлагын хамтарсан шийдвэрээр баталгаажуулдаг байх.

Энэхүү зохицуулалт нь зөвхөн төгсөгчдийн мэдлэг, ур чадварын чанарыг баталгаажуулаад зогсохгүй, боловсон хүчний төлөвлөлт, бэлтгэлийн тогтолцоонд захиалагч байгууллага болон боловсролын байгууллагын хамтарсан хариуцлагын тогтолцоо бүрдүүлэх боломжийг олгоно. Энэ нь мэргэжлийн боловсролын чанарын үнэлэмжийг нэмэгдүүлж, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах чухал нөхцөл болно.

Хэрэгжилтийн үр дүн ба сорилт.

Хилийн албаны мэргэжил эзэмшүүлэх үйл ажиллагааны эрх зүйн хэрэгжилтийн түвшинд хийсэн шинжилгээний дүнд тодорхой ахиц дэвшил болон үлэмж сорилтууд илэрч байна. Үүнд:

Нэгдүгээрт: Хилийн албаны мэргэжил эзэмшүүлэх сургалтын тогтолцоо нь боловсрол олгох нийтлэг тогтолцоонд тулгуурлаж байгаа нь эрх зүйн хувьд тодорхойлогдсон гэж үзэж болох боловч цэргийн боловсрол, тусгай чиг үүргийн онцлогт тохирсон эрхзүйн орчин шаардлагатай.

Хоёрдугаарт: Албан хаагчдын эрх, үүрэг, тавигдах шаардлагыг хилийн тухай, төрийн албаны тухай, цэргийн албаны тухай, цэргийн албан хаагчдын эрхзүйн байдлын тухай хуулиуд, мөн байгууллагын дотоод журам болон бусад эрх зүйн баримт бичгүүдэд тодорхой зааж өгсөн нь мэргэжлийн ёс зүйн төлөвшилд эергээр нөлөөлж буй давуу тал юм.

Гуравдугаарт: Дээд боловсролын тухай хуульд дэд бакалавр, бакалаврын зэрэг олгох эрх зүйн үндэслэл бүрэн тодорхойлогдсон боловч уг зэргийн ажил мэргэжлийн замнал, ажлын байрны тодорхойлолт, түүнийг хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалт нь Хил хамгаалах байгууллагын хүний нөөцийн бодлого, дүрмд тодорхой тусгагдаагүй хэвээр байна. Энэ нь сургалтын үр дүн, олгогдож буй боловсролын зэрэг, мэргэжлийн үнэлэмж, байгууллагын ажлын байрны шаардлага хооронд зөрүү үүсгэж,





ХУУЛЬ САХИУЛАХУЙН БОЛОВСРОЛ СУДЛАЛ

төгсөгчдийн хөдөлмөрийн үнэлгээ, албан тушаалын шат ахих тогтолцоонд тодорхой бус байдал бий болгож байна. Иймд Хил хамгаалах байгууллагын хүний нөөцийн дүрэмд дараах чиглэлээр зохицуулалт хийх шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

- ✓ Дэд бакалавр, бакалаврын зэрэгтэй төгсөгчийн ажлын байр, мэргэжлийн зэрэглэл, албан тушаалын тодорхойлолтыг нарийвчлан тогтоох;
- ✓ Боловсролын зэрэг ба албан тушаалын шат ахих тогтолцооны уялдаа холбоог эрх зүйн хувьд тодорхой болгох;
- ✓ Сургалтын үр дүнг хүний нөөцийн бодлого, цалин урамшуулал, албан тушаал дэвших нөхцөлтэй уялдуулан баталгаажуулах.

Эдгээр зохицуулалт нь боловсролын зэрэг олголт, ажлын байрны үнэлгээ, байгууллагын хүний нөөцийн бодлогын нэгдсэн уялдааг хангаж, төгсөгчдийн мэргэжлийн тогтвортой байдлыг баталгаажуулах чухал алхам болно..

Иймд эрх зүйн хэрэгжилтийн түвшинд гарсан дэвшлийг бататган бэхжүүлэхийн зэрэгцээ нэр томьёоны албан ёсны хэрэглээг хуульчилж баталгаажуулах;

Хөтөлбөрийн боловсруулалт, баталгаажуулалт, захиалагч байгууллагын оролцоо, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх;

Дэд бакалавр, бакалаврын зэргийн ажил мэргэжлийн замнал, ажлын байрны тодорхойлолт, түүнийг хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлага нэн тулгамдсан хэвээр байна.

Дүгнэлт, санал

Хилийн албаны мэргэжил эзэмшүүлэх үйл ажиллагааны эрх зүйн орчны хэрэгжилтэд судалгаа, шинжилгээ хийхэд дараах үр дүн тодорхой болов.

Нэгдүгээрт, хууль эрх зүйн зохицуулалтын түвшинд тодорхой ахиц бий болсон боловч “хилийн албаны мэргэжил” гэсэн нэр томьёо нь албан ёсоор хуульчилж баталгаажаагүйгээс сургалтын хөтөлбөрийн үндэслэл тодорхой бус

байдалтай хэвээр байна. Энэ нь мэргэжлийн үнэлэмж, боловсролын зэрэг олголт, хөдөлмөрийн зах зээл дэх хүлээн зөвшөөрөлтөд сөргөөр нөлөөлж байна.

Хоёрдугаарт, сургалтын хөтөлбөрийн боловсруулалт, баталгаажуулалтад захиалагч байгууллага болон боловсролын байгууллагын хамтарсан хариуцлагын тогтолцоо бүрдээгүй байна.

Гуравдугаарт, боловсролын зэрэг (дэд бакалавр, бакалавр)-ийн олголт нь эрх зүйн үндэслэлтэй боловч уг зэрэгтэй төгсөгчдийн ажлын байр, мэргэжлийн замнал, албан тушаалын уялдаа холбоо нь Хил хамгаалах байгууллагын дүрэм, хүний нөөцийн бодлогод тодорхой тусгагдаагүй байна. Энэ нь төгсөгчдийн мэргэжлийн тогтвортой байдалд эрсдэл дагуулж байна.

Иймд эрх зүйн орчныг боловсронгуй болгох, мэргэжлийн нэр томьёог хуульчилж баталгаажуулах, сургалтын хөтөлбөрийг захиалагч байгууллагын оролцоотой хамтран боловсруулах, хүний нөөцийн бодлогын зохицуулалтыг боловсролын зэрэгтэй уялдуулах шаардлагатай байна. Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлснээр хилийн албаны мэргэжил эзэмшүүлэх үйл ажиллагаа нь илүү оновчтой, нэгдсэн зохицуулалттай болж, мэргэжлийн өндөр ур чадвартай, эх оронч хүмүүжилтэй боловсон хүчнийг бэлтгэн гаргах бат бөх эрх зүйн үндэс бүрдэх юм.

Эх сурвалжийн жагсаалт

Боловсролын ерөнхий хууль. (2023). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем*. Retrieved from <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759958962301>

Дотоод хэргийн их сургуулийн дүрэм. (2024).

Дээд боловсролын сургалтын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага. (2024). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем*. Retrieved from <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140164626911&showType=1>

Дээд боловсролын тухай хууль. (2023). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем*.

- Монгол Улсын Үндсэн хууль. (1992). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем*. Retrieved from <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367>
- Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын тухай хууль. (2023). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем*. Retrieved from <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759959076531>
- Төрийн албаны тухай хууль. (2017). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем*. Retrieved from <https://www.legalinfo.mn/mn/detail/13025>
- Хил хамгаалах байгууллагын дотоод журам. (2021).
- Хилийн тухай хууль. (2016). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем*. Retrieved from <https://legalinfo.mn/mn/detail/12418>
- Ц.Ганболд. (2016). *Төрийн алба*. Улаанбаатар : Соёмбо прин.
- Цэргийн албан хаагчдын эрх зүйн байдлын тухай хууль. (2016). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем*. Retrieved from <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12125>
- Цэргийн албаны тухай хууль. (2016). Retrieved from *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем*: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12124>
- Цэргийн албаны тухай хууль. (2016). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем*. Retrieved from <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12124>
- Цэргийн албаны тухай хууль. (2016). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем*. Retrieved from <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12124>

